

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт	хувь
1.1 Төр засгийн бодлого шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх хүрээнд:		
1.1. Монгол Улсын Засгийн газар, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, суртачилах, биелэлтэнд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллах	Сумын бүх нөөц боломжоо орон нутгийн хөгжлийн төлөө зохистой ашиглах, иргэдийн эрэлт, хүсэлт, таашаалд нийцсэн ажил үйлчилгээг хүргэх зорилт тавин аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ЗДТГазраас удирдлага зохион байгуулалтыг оновчтой авч ажиллаа. Нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг ил тод нээлттэй хүргэх, чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор Засаг даргын иргэдтэй уулзах улзалтыг зохион байгуулан сум орон нутагт хийгдэх хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, төр, төсвийн байгууллагын үйл ажиллагааны талаар иргэддээ мэдээлэл хүргэн ажилласан.	100
1.2. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавих	Аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, биелэлтэнд хяналт тавьж үр дүнгийн биелэлтэнд хяналт шинжилгээ үнэлгээ хийн аймгийн ЗДТГазарт хүргүүлэв.	100
1.3. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хурлын ажиллах нөхцлийг хангаж ажиллах	Сумын ИТХурал болон багийн ИНХуралын ажиллах нөхцөл боломжийг ханган, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж ажиллаж байна.	100
1.4. Монгол Улсын Ерөнхийлөнчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, албан даалгавар, аймгийн Засаг даргын захирамж, албан даалгавар, ИТХ-ын тогтоолын хэрэгжилт, иргэдийн СӨГ-ыг шийдвэрлэсэн талаар хугацаанд нь тайлагнаж ажиллах	Тайлант онд МУЗГ-ын тогтоол 3, Аймаг ИТХурлын тогтоол шийдвэр 6, Аймгийн Засаг даргын албан даалгавар 3 ирж тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэн үр дүнг тайлагнан ажилласан байна. Тайлант хугацаанд төр төсвийн байгууллагын удирдлагуудад хандаж 812 өргөдөл гомдол ирж шийдвэрлэн ажилласан байна.	100
1.5. Хууль тогтоомжоор орон нутгийн хэмжээнд хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үр дүнг аймгийн Засаг даргын өмнө хариуцах	Сумын хэмжээнд эрх бүхий албан тушаалтанаас гаргаж буй захирамжлалын бүхий л бодлогын бичиг баримтыг ажил хариуцсан мэргэжилтнүүдээр боловсруулан, хууль эрх зүйн үндэслэл, цаг үеийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан гаргах, иргэд, ИТХ-ын төлөөлөгчид, Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан саналыг тусган ажиллаж байна. Нийгэм, эдийн засаг, хөгжлийн төлөвлөлт, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулалт хийгдэх томоохон бодлогын баримт бичгийг боловсруулахдаа зөвлөх үйлчилгээ авах, холбогдох мэргэшлийн байгууллагаар санал дүгнэлт гаргуулан ажиллаж байна.	100

<p>1.6. Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, дээд шатны байгууллагаас өгсөн цаг үеийн шуурхай үүрэг даалгавар, тайлан мэдээ, хариутай бичгийн биелэлтийг хугацаанд нь тайлагнаж ажиллах</p>	<p>Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан сум, багийн Засаг даргын захирамж шийдвэрийг аймгийн Хууль зүйн хэлтэст хянуулан ажиллаж байна. Төрийн байгууллагуудын албан бичиг хэргийн эргэлт, мэдээ мэдээллийн дамжуулалтыг шуурхай болгох зорилгоор “Байгууллагын удирдлагын цогц систем” /ABLE/-ийг нэвтрүүлж ажиллаж байгаа нь дээд газраас ирж байгаа албан бичиг, шуурхай мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээж авдаг, эргэж мэдээлдэг болсон нь чухал ач холбогдолтой боллоо. Сумын интернэт цахим вэб хаяг болон мэдээллийн боломжит хэрэгслээр иргэдэд ил тод харагдахуйц газарт байрлуулсан самбарт мэдээлэл байршуулан ажиллав. ЗДТГ-ын барилгын гаднах гудамж талбайн зориулалтай телевизээр мэдээлэл цацах ажлыг эхлүүлээд байна.</p>	<p>100</p>
<p>1.7. Орон нутагт иргэдийн оролцооны боловсролыг дэмжих, Иргэний танхимын үйл ажиллагааг эрчимжүүлж ажиллах</p>	<p>Сумын ЗДТГ-ын Иргэний танхимаар дамжуулан шинэчлэгдэн батлагдсан 7 төрлийн хууль тогтоомжийн Legalinfo.mn сайтаас татан авч 36 иргэнд үйлчлэв. Иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөөг өгч ажиллаа. Үүнээс гэр бүл цуцлалтын чиглэлээр 3 иргэнд нэхэмжлэл, Иргэн хоорондын эд хөрөнгийн маргаанд 15 иргэн нэхэмжлэл, нас тогтоолгох хүсэлт гаргах нэхэмжлэлийг 3 удаа бичиж өгч эрх зүйн дэмжлэг туслалцаа үзүүллээ. Сумын иргэдийн 30,4% эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг хийж 2 багийн давхардсан тоогоор 1180 иргэнд хамруулсан байна.</p>	<p>100</p>
<p>1.2.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хүрээнд:</p>		
<p>1.2.1.Төрийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээний үр нөлөөг дээшлүүлж, орон нутагт хяналт-шинжилгээ, үнэлгээний баг байгуулж ажиллуулах</p>	<p>Төрийн ажил үйлчилгээний чанар хүртээмж үр дүнд хийх хяналт шинжилгээний багийг ЗДТГазрын даргаар ахлуулсан ажлын хэсэг жил бүр ажиллаж хэвшиж байна</p>	<p>100</p>
<p>1.2.3.Бодлогын баримт бичиг, ажил үйлчилгээний хэрэгжилтийн явц, үр дүнд анхан шатны хяналт - шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг тогтмолжуулах</p>	<p>Төрийн албан хаагчдын ажлын гүйцэтгэл, ажлын ачаалал, үр дүнг харгалзан үр дүнгийн гэрээг дүгнэх, цалингийн урамшуулал олгох, хариуцлага тооцох замаар ажлын гүйцэтгэлийг үнэлж асуудлыг шийдвэрлэж байна. Жил бүр байгууллагын хамт олны хурлаар хэлэлцүүлэн баталсан дотоод журмаар төрийн албан хаагчтай холбоотой аливаа тулгамдсан асуудал, алдаа оноо ажлын ололт, дутагдалыг дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулан тодотгож ажиллаж байна.ТАХ-дын ажиллах нөхцөл, ажлын онцлог, цаг үеийн олон нийтийг хамарсан ажил, арга хэмжээ, байгууллагын дотоод ажил үйлчилгээ, байгууллага хамт олноо төлөөлөн оролцсон урлаг, спортын, ажил мэргэжлийн чиглэлээр амжилт гаргаж, хамт олноо манлайлан ажиллаж байгаа албан хаагчдыг</p>	<p>100</p>

	шагнаж урамшуулах, Яамны болон салбарын шагнал урамшуулалд тодорхойлох, мөнгөн урамшуулал олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 2017 онд нийтдээ 6 албан хаагчдад тус бүр 150.0 мян.төгрөг, 5 албан хаагчдад тус бүр 80,0 мян.төгрөг, 2 албан хаагчийг албан тушаалын цалингийн хувиар, 2 албан хаагчыг дээд шатны байгууллагын шагналаар шагнуулж урамшуулсан байна.	
1.2.4.Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна	100
1.3.Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах хүрээнд:		
1.3.1. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, иргэдэд хүнд суртал чирэгдэлгүй үйлчилж хэвших	Жил бүр байгууллагад мөрдөгдөх дотоод журамыг хамт олноороо хэлэлцэн батлаж, мөрдөж ажиллаж байна. Үйлдвэрчний эвлэл, Төрийн албан хаагчийн хичээн эрмэлзэх зүйл, нутгийн захиргааны байгууллагаас ИТХуралд үйлчлэх журам, иргэний танхимын үйл ажиллагааны журам болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж хэвшсэн	100
1.3.2."Байгууллагын дотоод удирдлагын цогц систем"-ийг үйл ажиллагаандаа хэвшүүлж, албан бичиг, шуудан мэдээ тайланг солилцоход ашиглаж ажиллах	ЗДТГ-ын архив, бичиг хэргийн мэргэжилтэнд хариуцуулан ажиллаж байна.Төрийн албанд иргэдийг чирэгдэлгүй үйлчлэх талаар чиглэл үүрэг өгч, иргэдийг 1 цонх, иргэний танхимаар хүлээн авч уулзаж, тэдний санал бодлыг сонсч ажиллаа.	100
1.3.3.Сумын цахим хуудасны байнгын, тасралтгүй үйл ажиллагааг хангаж, мэдээ мэдээллийг тогтмол шинэчлэх	Сум орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил, цаг үетэй холбогдолтой бусад мэдээллийг ЗДТГ-ын Facebook хаягт тогтмол нийтэлж ажиллаж байна. Суманд үйл ажиллагаа явуулдаг "Хүчин бүрэн ХХК" нийгмийн хариуцлагын гэрээний үүргийн дагуу ЗДТГазрын гадна хананд 5700,0 мянган төгрөгийн өртөг бүхий Led дэлгэц авч өгсөн боловч одоогоор самбар тогтмол ажилд ороогүй байна.	100
1.3.4.Төрийн ажил үйлчилгээний талаарх мэдээ мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах арга хэмжээг шинэ шатанд гаргах	2017 онд "Хүдэрийн мэдээ" сонинг улирал бүр гарган мэдээ мэдээллийг хүргэн ажиллаж байна. Тайлант хугацаанд 1200 сонин хэвлэж 1350,0 мянган төгрөг зарцуулсан байна. Мөн иргэдэд цаг үеийн холбогдолтой мэдээ мэдээллийг хүргэх зорилгоор иргэний танхимд Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ, Сэлэнгийн мэдээ сонин тогтмол захиалан хүргэж байна.	100
1.3.5.Орон нутгийн хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөсөн ажил, арга хэмжээний талаар аймгийн ЗДТГ болон иргэдэд урьдчилан мэдээлж ажиллах	Тайлант онд орон нутагт нилээдгүй олон ажил арга хэмжээг зохион байгуулан ажиллаа. Үүний дотор 2017 онд манай сум бүтээн байгуулалт хөрөнгө оруулалтын ажлуудыг хийж гүйцэтгэн хүлээн авч ашиглалтанд оруулсан	100
1.3.6. Хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан ажилтнуудыг чадавхжуулж, орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	Хэвлэл мэдээллийн ажлыг НБХЭХариуцсан мэргэжилтэнд хариуцуулж чадавхижуулах сургалтанд хамруулан ажиллаж байна.	100

1.4. Хүний нөөцийн хөгжлийг хангах		
1.4.1.Төрийн албан хаагчдыг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх, боловсролын зэрэг ахиулахад бодлогын дэмжлэг үзүүлэх	Тайлант хугацаанд төрийн албан хаагчдын нийт 12 удаагийн урт богино хугацааны сургалтанд хамруулсан байна. Мөн БНХАУ-ын Эрээн хотод туршлага судлах сургалтанд 25 албан хаагч хамрагдсан байна.	100
1.4.2. Байгууллага бүрийн сургагч байгууллага болгох зорилтыг хэрэгжүүлж, сургалтын төлөвлөгөөг боловсруулж ажиллах	Хэрэгжээгүй	0
1.4.3.Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны захиалгыг авч, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд тухай бүр мэдээлж ажиллах	2017 онд сумын ЗДТГазарт төрийн албан болон хөдөлмөрийн, иргэний тухай хуулийн холбогдох асуудлаас шалтгаалан гарсан төрийн албаны сул орон тооны талаар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгч, сонгон шалгаруулалтанд орж тэнцсэн иргэдээс төрийн албаны зөвлөлийн тогтоол шийдвэрээр, хуулийн дагуу ажлын байранд томилж төрийн албаны залгамж халаа, төрийн ажлын тасралтгүй байдлыг хангуулан зохион байгуулж ажиллаа. ЗДТГазар төрийн захиргааны 3 албан тушаалтан, төрийн үйлчилгээ гэрээт 2, ажилтанг, ЕБСургуульд багшаар 5 ажилтанг, СӨБ-ын байгууллагад 4 ажилтанг ЭМТөвд 2 ажилтанг тус тус сул орон тоог хуулийн дагуу нөхөн бүрдүүлэн ажиллаа.	100
1.4.4.Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг тогтоосон хуваарийн дагуу мэдээлэх нөхөн арга хэмжээг авч ажиллах	ТАХ-ын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг тогтоосон хугацаанд өгч хэвшсэн	100
1.5.Гадаад харилцаа, хамтын ажиллагаа		
1.5.1.Гадаадад айлчлах, албан хэргээр зорчих, олон улсын арга хэмжээнд оролцох албан ёсны хэлцэл байгуулахдаа дээд шатны байгууллага, албан тушаалтны удирдамжийн дагуу ажиллах	Тайлант онд гадаад дотоод албан томилолтоор ажиллаагүй болно	
1.5.2.Албаны гадаад паспортыг аймгийн Засаг даргын тамгын газрын даргад хадгалуулж, ажлаар гадаадад зорчиход олгож, гадаад албан томилолтоос буцаж ирэхэд эргүүлэн авдаг журмыг мөрдөж ажиллах	Албаны паспорт авсан алба хаагч байхгүй болно	
1.5.3.Орон нутгийн түвшинд өөрийн сумын онцлогт нийцсэн гадаад харилцааны бодлогыг тодорхойлон, шинэ түншлэлийг эрэлхийлж ажиллах	Хэрэгжээгүй	0

<p>1.5.4.Гадаад, дотоодод албан томилолтоор болон хувийн ажлаар явахдаа аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, Тамгын газрын даргад албан ёсоор хандаж, чөлөө зөвшөөрөл авч ажиллах</p>	<p>Тайлант онд гадаад дотоод албан томилолтоор ажиллаагүй болно.</p>
<p>1.6. Бусад ажил арга хэмжээ</p>	
<p>1.6.1.Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p>	<p>Малын гоц халдварт цэцэг өвчин гарч мал эмнэлгийн албаны заавар зөвлөмжийн дагуу шуурхай арга хэмжээ авч сумын засаг даргын А/5 захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоож ажилласнаар өвчний голомтыг таслан зогсоох арга хэмжээ авч хэрэгжүүлж байна. Сумын хэмжээнд 9 малчин өрхийн 1657 хонь уг өвчнөөр өвчилж,өвчилсөн бүх хонийг устгалд оруулсан болно. Сумын нийт малчин өрхийн 90 суурьт байгаа 12256 хонинд цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтанд бүрэн хамруулав. Устгал вакцинжуулалтын арга хэмжээнд 14 машин техник ,89 хүн ажиллав. Хорио цээрийн 4 пост ажилласан.Засаг даргын А\81 захирамжийн дагуу Хүдрийн адагаас эхлэн Жаргалант, Хазай, Нарийн хөдий, Төмөртэй, Ганц модны энгэр, Дөрөө хавирдаг, Тарвагатай, Шанд, Бумбат, Төхөмийн хөндий, Цагаан нуга, Уялга, Цагдаа овоо зэрэг газруудад аймгийн мал эмнэлгийн дук машинаар 5-р сарын 29-ны өдрөөс эхлэн 6-р сарын 12-ны өдрийн хооронд 118 өвөлжөөнд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэлээ. Мөн малын гоц халдварт цэцэг өвчний голомттой 9 суурийн зусланд байгаа хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.</p>
<p>1.6.2.Үйлдвэрлэл, үйлчилгээний стандартын шаардлага ханган ажиллаж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах</p>	<p>Хэрэгжээгүй</p>
<p>1.6.3.Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх, зөвлөн туслах үйлчилгээг Мэргэжлийн хяналтын газартай хамтран хэрэгжүүлэх</p>	<p>Ойн тухай хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах зорилгоор удирдамжийн дагуу хяналт шалгалтыг 5 удаа хийж нийт 12 иргэн,15 аж ахуй нэгж, 7 нөхөрлөл шалгалтанд хамрагдлаа. Шалгалтын явцад Ойн тухай хууль зөрчсөн Баянцагаан 2-р багийн иргэн Б.Өлзийутас модны нөхөн төлбөр болох 785,000 төгрөгийг оногдуулж 7м3 гуалин хурааж улсын орлого болгосон. Мөн Тарвагатай 1-р багийн иргэн Б.Энхбаярын хууль бусаар бэлтгэсэн модыг хураан авч холбогдох байгууллагад шилжүүлсэн. 2017 оны жилийн эцсийн байдлаар зохих зөвшөөрөлгүй бэлтгэгдсэн 60 м3 модыг хураан улсын орлого болгосон. Мөн аймгийн мэргэжлийн хяналт болон БОАЖЯам ажлын хэсэгтэй хяналт шалгалтыг хийж зохих зөвшөөрөлгүй хийж бэлтгэгдсэн 115 м3 модыг хураан улсын орлого болгон дуудлага</p>

	<p>хуралдаанд оруулж орон нутгийн төсөвт 26,000,000 төгрөгийг оруулсан. Дархан төмөрлөг ТӨХК-ны олборлолтын талбайд өртөх модны төрөл хэмжээг гарган нийт 78,300,000 төгрөгийг төсөвт оруулсан. Мөн иргэдийн мэдээллийн дагуу Ойн тухай хууль зөрчсөн Ц.Ачхүү, Хүдэрбаатар, Хашэрдэнэ, Тэгштогтох, Адууч, Гомбо, Билгүүн нарын Галагтай нэртэй газраас зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн 47,5 м3 модыг хураан авч цагдаагийн байгууллагад шилжүүлсэн.Суманд одоогийн байдлаар ойн санг гэрээгээр эзэмшигч 22 аж ахуй нэгж, 24 нөхөрлөл үйл ажиллагаа явуулж байгаагаас ойд үйлдвэрлэл, арчилгаа, цэвэрлэгээний огтлолын эрхтэй 15 мэргэжлийн байгууллага бүртгэлтэй байна. Хэрэглээний мод 19950 м3, түлээний мод 13740 м3 модны хуваарь батлагдаж энэ оны 11-р сарын 15-ны өдрийн байдлаар хэрэглээний мод 11571 м3, түлээний мод 2117 м3 бэлтгэгдсэн. Нийтдээ 577 ш гарал үүслийн гэрчилгээ олгогдож 345 ш эрхийн бичиг олгогдож 13080 шоо метр мод гадагш тээвэрлэгдсэн байна.</p>	
--	---	--

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт	Хувь
<p>2.1."Бүх нийтийн эрх зүйн боловсрол хөтөлбөр"-ийг боловсруулж, хууль тогтоомжийн талаар сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг төлөвлөгөө хуваарийн дагуу зохион байгуулах</p>	<p>Аймгийн "Бүх нийтийн эрх зүйн боловсрол" хөтөлбөрт оруулах саналыг сумын иргэдээр хэлэлцүүлэг зохион байгуулж гарсан санал санаачлагыг Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлэн ажилласан.</p>	<p>100</p>
<p>2.2.Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, хүний эрхийг хангах олон талт арга хэмжээг хэрэгжүүлж, хуулийн хэрэгжилтийг чанд мөрдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг буруулан, иргэдийн аюулгүй амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилтууд, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлийн хууль эрх зүйн зорилтуудыг хэрэгжүүлж, тайлагнах.</p>	<p>Сумын нийт хүн амын эрх зүйн боловсрол мэдлэгийн түвшин иргэдийн хэргэцээ шаардлагад үндэслэн Эрх зүйн сургалтын төлөвлөгөөг жилээр боловсруулан шаардагдах санхүүжилтын асуудлыг шийдвэрлүүлэн 32 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 2632 иргэн хамрагдсан байна. Орон нутагт эрх зүйн сургалт сурталчилгааг хүргэхийн тулд ЗДТГазрын Иргэний танхим, сумын Соёлын төвийг түшиглэн эрх зүйн сургалт сурталчилгааг хууль тогтоомж болон Төрийн албан хаагчидтай хамтран зохион байгуулж ажиллаа. Хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилах хэлбэрээр явуулж 4-5 сард "Хүлээж биш хүрч үйлчилье", "Даатгагдсан ирээдүй", "Ногоон хөгжил - Бидний оролцоо", "Хөрс усны бохирдол", "Хүний эрх ба зөрчил", гэх зэрэг аян зохион байгуулан ажилласан. 2, 3, 4, 5 сард татварын хөнгөлөлт чөлөөлөлт, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, нийгмийн даатгалын багц хууль, захиргааны ерөнхий хууль, нийтийн сонсголын тухай хууль, ойн тухай хууль, нийгмийн халамжийн тухай хууль зэрэг хуулиудыг сурталчилан ажилласан. 8, 9, 10, 11 сард Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, авто машины албан татварын тухай хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар сургалт сурталчилгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.</p>	<p>100</p>
<p>2.3.Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах албар зөвлөлийн дэргэд олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллах, "Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга</p>	<p>Байгууллага бүр өөрийн салбарын онцлогтоо тулгуурлан байгууллагын соёл, дотоод дүрэм журам стандартад нийцүүлэн дотоод ажиллах хүчний зохион байгуулалт, өдөр тутамын ажил үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.жилд 4 удаа улирал бүр, шаардлагатай цаг тухай бүрд нь төрийн ажил үйлчилгээний талаар иргэдээс ТАХ-дын ажил, төрийн болон төсөвт</p>	<p>100</p>

<p>ёсыг бэхжүүлэх аймгийн хөтөлбөр"-ийг боловсруулж, хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг төлөвлөгөө, хуваарийн дагуу зохион байгуулах</p>	<p>байгууллагаас иргэдэд үзүүлж буй ажил үйлчилгээ, нийтийг хамарсан олон талт арга хэмжээтэй холбогдуулан сэтгэл ханамжийн судлагааг түүвэрлэн авч, ТЗ-ны албан тушаалтануудын ажил дүгнэх үзүүлэлтэнд үр дүнг тооцон ажиллаж хэвшсэн</p>	
<p>2.4.Хүний эрх зөрчигдөж байгаа зөрчил, дутагдлыг арилгах чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран сургалт, зөвлөгөөн, хяналт шалгалт зохион байгуулж, үр дүнг иргэд, олон нийтэд сурталчлах, “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2015-2018 оны арга хэмжээний төлөвлөгөө”-г үр дүнтэй хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах</p>	<p>Тайлант жилд Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагтаа зохион байгуулан ажиллаж ирлээ. Үүний нэг ажил болох “Хүний эрхийн төлөө хамтдаа аян”-ыг зохион байгуулан ажилласан. Сарын аяны хүрээнд ААНэгж байгууллагуудад сарын аяны удирдамжийг хүргүүлэн үйл ажиллагааг дүгнэн ажиллаа.</p> <p>Сургалт сурталчилгааны чиглэлээр: Сарын аяныг сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран “Хүний эрх ба зөрчил” уриалагын дагуу зохион байгуулж ажилласан. Энэ ажлын хүрээнд 12-р сард иргэдэд эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг дараах чиглэлээр хүргэн ажиллаа. Үүнд: Эрх зүйн сургалт сурталчилгааг 4-р улиралд “Хүний эрх ба зөрчил” сэдвийн дор явуулж ЗДТГазрын алба хаагчид болон Цагдаагийн хэсэгтэй хамтран зохион байгууллаа. Сургалтыг дараах чиглэлээр зохион байгуулж 71 иргэн хамрагдсан байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ✚ Зөрчлийн тухай хууль ✚ Хүний эрх /Халдашгүй дархан байх эрх/ ✚ Гэр бүлийн хүчирхийлэлийн тухай хууль ✚ Архи согтууруулах ундааны хор уршиг, гэмт хэргийн нөхцөл байдал ✚ НӨАТУС ✚ Нийгмийн даатгалын тухай хууль ✚ Нийгмийн халамжийн тухай хууль ✚ Ойн тухай хууль зэрэг хууль <p>тогтоомжоор сургалт сурталчилгааг хүргэхээс гадна иргэдэд хүний халдашгүй дархан эрхийн талаар видео хичээл үзүүлж хүний эрхийн талаарх тараах материалыг хүргэн ажиллаа. Мөн сумын цагдаагийн хэсэгтэй хамтран архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж Архины хор хөнөөлийн талаар зөвлөгөөг иргэнд өглөө. Гэмт хэрэг зөрчилөөс урьдчилан сэргийлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр сумын төвд сүүлийн үеийн эргэдэг / ip 2pixeltei ip/ камер суурилууллаа. Уг камерийг цагдаагийн кувонгоос дэлгэцээр байнгын хянах ба 24 цагийн ажиллагаанд байлган ажиллаж байна</p>	<p>100</p>

<p>2.5.Аймгийн Засаг даргын 2010 оны 93 дугаар захирамжийн дагуу сар бүрин “3 дахь 7 хоног”-т хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлыг иргэдийн санал хүсэлтийг харгалзан зохион байгуулж, сумын нийт хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулах</p>	<p>Сумын иргэдийн 30,4 %-д эрх зүйн сургалт сурталчилгааны ажлыг хийж 2 багийн давхардсан тоогоор 1180 иргэнд хамруулсан байна. Сумын иргэдийн 61 хувьд сурталчилгааны ажил хийж 14 төрлийн хуулиар хууль тогтоомжоор 3800 орчим боршур тараасан байна.</p>	<p>100</p>
<p>2.6. Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэрийн хувийн хэргийг шинээр бүрдүүлэн, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх ажлыг хуулийн хүрээнд зохион байгуулах</p>	<p>Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төр, төсвийн байгууллагаас гаргаж байгаа нийтээр дагаж мөрдөх журмалсан шийдвэрийг гаргахдаа Захиргааны ерөнхий хуулийн 60-р зүйлийг мөрдлөг болгон ажиллах талаар сургалт сурталчилгааг хүргүүлэн ажиллаж байна. 2017 онд сумын Засаг даргаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргаагүй болно.</p>	<p>100</p>
<p>2.7.Архидан согтуурахтай тэмцэх хууль түүнтэй нийцүүлэн гаргасан дүрэм журмуудыг мөрдөж, аймгийн “Архидалттай тэмцэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэн, архи согтууруулах ундаа худалдах, үйлчлэх цэгийн тоог тогтоосон норматив хэмжээнд хүргэж, архины зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх</p>	<p>1.“Архигүй аж ахуй нэгж” зорилтод хөтөлбөрийн хүрээнд: Суманд үйл ажиллагаа явуулдаг ААНэгжид хөтөлбөрийн зорилгыг танилцуулж “архигүй аж ахуй нэгж ” нэртэй уралдаан тэмцээний зохион явуулсан ба уг үеэр Сумын Цагдаагийн хэсэгтэй хамтран шинэчлэгдэн батлагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн зүйл заалтаар мэдээлэл хүргүүлэн ажилласан байна.Архигүй аж ахуй нэгжийг бий болгох, Архины хор хөнөөл, түүний үр дагаварын талаар жижиг киног бэлтгэн Төрийн захиргаа хууль, эрх зүйн мэргэжилтэн, бага эмч, хэсгийн төлөөлөгч нар аж ахуй нэгж тус бүрээр зочлон сургалтыг явуулж архи гэж юу вэ? сэдэвтэй гарын авлагыг 186 иргэнд тараан ажилласан.Хөтөлбөрийн хүрээнд “Архигүй ирээдүй” уриаг аж ахуй нэгжийн ажилчдын хамтаар гаргаж сургалт сурталчилгааг ажлын байранд нэртэй хэвлэмэл материалыг аж ахуй нэгжийн ажилтнуудаар нь хуваарь гарган хүргүүлж ажиллаа.Ажлын байранд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг сахин биелүүлэх, гарч буй эрсдэлээс урьдчилан сэргийлэх анхаарал болгоомжтой ажиллаж байх, ажлын байранд архины хэрэглээгүй байх талаар БОХУБайцаагч, Хэсгийн төлөөлөгч, ТЗХЭЗМэргэжилтэн, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөлийн хамтаар яриа таниулгыг хийж аж ахуй нэгжийн ажилчдаас баталгааг авч байнгын анхаарал болгоомжтой байх талаар дарга, захирал нарт нь байнгын үүргийг хүргүүлэн ажилласан.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн гишүүдийн хамтаар Архигүй аж ахуй нэгж, хамт олонг шалгаруулах, үе шаттай шалгалтыг зохион</p>	<p>100</p>

явуулж байр эзлүүлэх хэсэгчилсэн арга хэмжээг 2 удаа зохион явуулсан байна.

2. “Архигүй албан байгууллага”

хөтөлбөрийн хүрээнд: Сумын төр төсвийн байгууллага болох ЗДТГазар, Цэцэрлэг, ЕБСургууль, ЭМТөв, Соёлын төв зэрэг байгууллагуудад хөтөлбөрийг хүргүүлэн заасан ажлуудыг хийж гүйцэтгүүлсэн ба байгууллагуудын ГХУСЗөвлөлтэй хамтран сургалтууд, гарын авлага материал тараах төлөвлөгөөг гаргаж ажилласан байна. Уг хөтөлбөрийн хүрээнд байгууллагуудын ажилчид, алба хаагч нарт улирал тутам хуулийн талаархи мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор АСТТХууль, ЭХууль, архины хор хөнөөлийн талаарх сургалтыг зохион байгуулсан байна. Албан байгууллагын дарга нарт албан хаагчид ажлын байран дээр архи согтууруулах ундааг хэрэглэхгүй байх ард иргэдтэй зөв боловсон харьцах, баяр ёслолыг архигүй тэмдэглэн өнгөрүүлж хэвших, “Архигүй хамт олон” болох талаар албан мэдэгдэл хүргүүлэн хяналт шалгалтыг Сумын ГХУСАЗСЗөвлөлтэй хамтран хийж гүйцэтгэж байна. Мөн нийт төрийн албан хаагчдын дунд Аймгийн Архидалттай тэмцэх хөтөлбөрийн талаарх сургалтыг аймгийн Цагдаагийн газрын ахлах байцаагч цагдаагийн хошууч Цэрэнбат сургалт хийж сургалтанд 42 албан хаагч хамрагдсан.

3. “Архигүй айл, өрх” зорилтын

хүрээнд: Сумын тарвагатай 1-р баг, баянцагаан 2-р баг нийт 648 өрх айлтай 10 хэсгийн ахлагтай ажилладаг ба багуудын ГХУССЗөвлөлийн гишүүдтэй хамтран ажилдаг ба архины хэрэглээтэй иргэдийн судалгааг багуудад гаргаж түүнд чиглэсэн тодорхой ажилгаануудыг багийн засаг дарга, цагдаагийн хэсэгтэй хамтран хэрэгжүүлж байна. Айл өрхийг архины хэрэглээгүй болгох талаар архигүй гэр бүл, архигүй гудамж, та битгий архи зар сэдэвтэй уулзалт ярилцлагын улирал бүр зохион байгуулж ажиллаж байгаа ба иргэдээс гаргаж байгаа саналыг авах зорилгоор зочин айл нэртэй дэвтэрт саналыг тусган ажилдаа хэрэгжүүлж ажилласан. Гар дээрээс архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг айлуудын судалгааг гаргаж гарсан зөрчлийг арилгуулан баталгаа авч суманд хэрэгжүүлж байгаа архины эсрэг хөтөлбөрийг нийт ард иргэдэд таниулж гарын авлага материал тараан ажилсан. Сумын ард иргэдэд Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэсэг, ЗДТГазрын алба хаагч нарын хамтаар архины хор хөнөөл, архи айл өрх, гэр бүлийн хүчирхийлтэй тэмцэх чиглэлээр сургалтыг

	нийт 153 иргэнд зохион явуулж ажилсан байна.Байнгын архи уудаг, хэвшмэл иргэдэд архинаас гаргах арга зам нэртэй гэр бүл, ах дүү, эхнэр хүүхдүүдийн хамтаар уулзаж ярилцан архинаас гаргах арга хэмжээг ямар байдлаар авч хэрэгжүүлэх талаар ярилцлагыг явуулж ажиласан.	
2.8. “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийг боловсруулж, хууль тогтоомжийн талаарх сургалт, хэлэлцүүлэг, сурталчилгааны ажлыг төлөвлөгөө хуваарийн дагуу зохион байгуулах	Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 2017 онд хийх ажлын төлөвлөгөөг баталж, ажил үүргийн хуваарь гаргаж хуваарьт заасан тодорхой ажлуудыг хугацаанд нь хийж гүйцэтгэн ажиллаж байна.	100
2.9.Засгийн газрын 2015 оны 257 дугаар тогтоолоор батлагдсан “Олон нийт-цагдаагийн хамтын ажиллагаа” хөтөлбөрийн хүрээнд сумын Засаг дарга, хэсгийн төлөөлөгч, иргэний зөвлөлтэй хамтарсан “Түншлэлийн гэрээ”-г байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах	Хэрэгжээгүй.	0
2.10. Цагдаагийн байгууллага, алба хаагчаас орон нутгийн төсөвт оруулсан нийт орлогын 20 хүртэлх хувийг цагдаагийн алба хаагчийн ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд зарцуулах, гэр бүлийн хүнийг ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	Цагдаагийн хэсгийн ажилчдын ажиллах нөхцөлийг сайжруулах зорилгоор албанд нь Ланд круйзер маркын авто машин засварлахад 10 сая төгрөг, албаны техник хэрэгсэлийг шинэчилэхэд зориулж 2900,0 мянган төгрөг, нисдэг камер авахад зориулж 4500,0 мянган төгрөг зарцуулсан байна. Гэр бүлийн хүн нь ЗДТГ азарт ажилладаг	100
2.11.Харъяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчид “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-д заасан үйлчилгээ үзүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх, шаардагдах зардлыг санхүүжүүлэх, хуулийг сурталчилж, зорилтот бүлгүүд болон хүчирхийлэл үйлдэгчдэд сургалт сурталчилгаа явуулах	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр салбар төлөвлөгөөг хамтарсан багийн гишүүдийн хамтаар гаргаж шинээр батлагдсан “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”-ийг ард иргэдэд таниулах сурталчлах, хуулийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ЗДТГ азартай хамтран 3 удаа зохион байгуулан ажилласан.Гэр бүлдээ айдас түгшүүр төрүүлдэг иргэдийн судалгааг нийгмийн ажилтангийн хамтаар гарган судалгаанд авч нэг бүрчлэн уулзаж зөвөлгөөг өгч ажилласан.Энэ онд гэр бүлийн хүчрхийлэлтэй тэмцэх ажилд ямар нэгэн зардал гаргаагүй болно.	100
2.12. Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг болон хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох тодорхой ажил зохиож, үр дүнд хүргэх	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр сумын унаган толгой болон машинтай зам шалгалтын ажлыг байгаль орчны алба, хөдөө аж ахуйн тасагтай хамтран осол хэргээс урьдчилан сэргийлэх талаар гарын авлага гарган нийт 78 ширхэг тарааж шинээр засмал зам ашиглалтанд орсонтой холбоотойгоор замын хэсэг, тэмдэг, тэмдэглэлгээг сайжруулан түнийг сурталчлах яриа таниулгыг хийж ажилласан.Хүний амь нас, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр шинээр батлагдсан эрүүгийн хуулиар 3 удаагийн сургалтыг зохион байгуулан 48 иргэн хамрагдсан.	100

<p>2.13. Хүн худалдаалах, хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт сурталчилгаа зохион байгуулж, энэ төрлийн зар сурталчилгаанд хяналт тавих</p>	<p>Манай суманд энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдээгүй бөгөөд урьдчилан сэргийлэх чиглэлээр ний 3 удаагийн сургалтыг зохион байгуулж 48 иргэн хамрагдсан байна.</p>	<p>100</p>
<p>2.14. Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулж, зохион байгуулах</p>	<p>Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх ажлыг байгаль орчны албатай хамтран байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд болон “Мод” хэсэгчилсэн арга хэмжээг ГХУСАЗСЗөвлөлийн дарга, Засаг дарга нараар батлуулан үр дүнг танилцуулан ажилласан ба мод бэлтгэх аж ахуй нэгж болон иргэдэд хууль сурталчлах аян зохион байгуулж улирал бүр гарын авлага, зөвлөмж бэлтгэн давхардсан тоогоор, 26 аж ахуй нэгж, нөхөрлөл, 214 иргэнд тарааж ажилсан.</p>	<p>100</p>
<p>2.15. Нотариатчийн үүрэг гүйцэтгэгч нарыг нотариатын үйлдэл хийхтэй холбогдуулан чадавхижуулах сургалтанд хамруулж, холбогдох зардлыг хариуцах</p>	<p>Нотариатын үүрэг гүйцэтгэгчээс жилийн эцсийн байдлаар 500 хүнд нотариатын үйлчилгээг үзүүлж 2916,0 мянган төгрөгийн орлогыг сумын төсөвт оруулсан</p>	<p>100</p>
<p>2.16. Архивын ажил үйлчилгээг сайжруулж байр, зориулалтын техник хэрэгслээр ханган, байгууллагын удирдлагын цогц /able cloud/ программыг төрийн албан хэрэг хөтлөлтөнд ашиглан стандарт, заавар журмыг мөрдөж ажиллах</p>	<p>Архивын өрөөг тусд нь гаргаж баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор зориулалтын шкаф 5, компьютер 1-тэйгээр байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн ЗДТГ-аас төрийн байгууллагуудын албан бичиг хэргийн эргэлт, мэдээ, мэдээллийн дамжуулалтыг шуурхай болгох зорилгоор “Байгууллагын удирдлагын цогц систем” /ABLE/-ийг нэвтрүүлж ажилласнаар дээд газраас ирж байгаа албан бичиг, шуурхай мэдээ, мэдээллийг цаг алдалгүй хүлээн авч байна. 2017 онд төрийн байгууллагын цахим болон бичиг хэргийн intranet хаягаар нийт 699 тоот ирсэн үүнээс хариутай 299 тоот ирснийг удирдлагуудад танилцуулан цохолтын дагуу холбогдох мэргэжилтэнгүүдэд хүргүүлэн хариуг цаг тухайн үед нь явуулах тал дээр анхаарч ажиллаж байна.</p>	<p>100</p>
<p>2.17. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг хэрэгжүүлж, бүртгэл судалгааг хуулийн дагуу явуулан тайлан мэдээг аймгийн ЗДТГ-т сар бүр мэдээлж тайлагнах</p>	<p>Тус суманд албан ёсны бүртгэлтэй гадаадын иргэн байхгүй болно.</p>	
<p>2.18. Суманд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад хяналт тавьж, зөвшөөрөлгүй сүм хийдийн үйл ажиллагааг таслан зогсоож, хуулийн этгээдийн бүртгэлд хамруулж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах</p>	<p>Тус суманд зөвшөөрөлгүй болон зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулдаг сүм, хийд байхгүй болно.</p>	

<p>2.19. Нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын дарга нараас гаргаж буй тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулахад онцгой анхаарч, хууль бус шийдвэр гаргалгүй иргэн, хуулийн этгээдийн эрх, ашгийг зөрчихгүй ажиллах</p>	<p>Нутгийн захиргааны болон төсвийн байгууллагуудын дарга нараас гаргаж буй тушаал, шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хангуулахад Төрийн захиргаа, хууль, эрх зүйн мэргэжилтэн хяналт тавьж хууль бус үндэслэлгүй шийдвэр гаргахгүй байлгах тал дээр захирамжийн төслийг хянуулах тойрох хуудас явуулж хянан баталгаажуулан ажиллаж байна.</p>	<p>100</p>
<p>2.20. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж, тайлан мэдээг дурьдсан хугацаанд ирүүлэх</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 25 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг хэсгийг байгуулан орон нутагт зохион байгуулж холбогдох тайлан мэдээ тайланг хүргүүлэн ажилласан.</p>	<p>100</p>
<p>2.21.Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулж, хууль зүйн туслалцааны төвтэй болох асуудлыг судлан шийдвэрлэх</p>	<p>Хамааралгүй</p>	
<p>2.22.Хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бүх шатны сургууль, төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлж, тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж, “School police” арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх</p>	<p>Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Ерөнхий боловсролын сургууль дээр гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Гал тоглоом биш” сургалтыг Хан хэнтий дархан цаазат газар, Цагдаагийн хэсэгтэй хамтран явууллаа. Тус сургалтанд 6-12-р ангийн нийт 127 хүүхэд оролцлоо. “Хүүхэд ба зөв гэр бүл”сэдэвт сургалтыг захирал Г.Цэрэндамба удирдан явуулж, нийт 32 эцэг эхийг хамрууллаа.“Хүн байхын учир” сургалтыг зохион байгууллаа. Үүнд 9-12-р ангийн 20 сурагч, 96 эцэг эх хамрагдлаа.Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017.05.05-ны өдрийн 1 472, Сумын Засаг даргын 2017.05.08-ны өдрийн 1/106 тоот албан даалгаврыг хэрэгжүүлж сургуулийн 51 ажиллагсадыг хамруулан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Архидалтай тэмцэх”, “Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм”сэдвийн дор сургалт сурталчилгааг зохион байгууллаа.“School police” арга хэмжээг зохион байгуулан хэвшиж ажиллаж байна.</p>	<p>100</p>
<p>2.23.“Нэг баг-нэг агт”, “Нэг аж ахуйн нэгж-нэг мотоцикл” аяныг хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</p>	<p>Хил хамгаалах албыг бэхжүүлэх зорилгоор сумын 0236-р салбар ангид 20,0 сая төгрөгийн өртөг бүхий цасны чаргыг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гарган авч өгсөн.</p>	<p>100</p>
<p>2.24. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дэргэд олон нийтийн хяналтын дэд зөвлөлийг байгуулан ажиллах</p>	<p>ГХУСАЗСЗөвлөл нь 2017 онд нийт 4 удаа хуралдсан ба хурлаас гарч байгаа шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Энэ онд “Яргүй” “Түймэр” “Мал” “Зэвсэг” нэртэй нэгдсэн болон, хэсэгчилсэн арга хэмжээнүүд хэрэгжүүлж ард игэдэд гарын авлага материал бэлдэн тарааж ажилласан байна.Архи уун согтуурсан, ар</p>	<p>100</p>

	<p>гэртээ агсам тавьж иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан иргэдэд анхааруулга сануулга өгөн торгуулын арга хэмжээ авч, гудамж талбай олон нийтийн газраар өдрийн болон шөнийн эргүүлийг хийж худалдаа үйлчилгээний газруудад албан мэдэгдэл өгч хариуг авч ажилласан. Сумын Ой анги, Байгаль орчны албатай хамтран эргүүл шалгалтыг төлөвлөгөө гарган батлуулж түүний хэрэгжилтийг ханган гарсан зөрчлийг арилгуулан ажилласан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуй нэгжүүд, Багийн Засаг дарга нарт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар хугацаатай албан мэдэгдэл өгсөн ба Сумын нийт иргэдийг хамарсан баярын үйл ажиллагааны хамгаалалтанд гарч нийгмийн хэв журам хамгаалан ажиллаж төр төсвийн байгууллагад эргүүл жижүүрийн хуваарийг гаргуулж ажилласан. Сумын хэмжээнд гэмт халдлагад өртөж болзошгүй объектууд болох “ШТСанц”, ” ХААН “ “ ТӨРИЙН ” банк зэргүүдэд харуул хамгаалалтыг сайжруулхаар албан мэдэгдэл өгч харуул хамгаалалтыг шалгаж ажиллаж байна.</p>	
<p>2.25. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлж, эрчимжүүлэх</p>	<p>Малчин болон мал бүхий иргэдэд ГХУСТухай хуулийн зүйл заалтаар бэлтгэсэн агрын авлаг, зөвлөмжийг нутгийн онцлогт тохируулан 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулж нийт малчин өрхөөр явж анхааруулгыг өгсөн ба Хөдөө аж ахуйн тасагтай хамтран нүхэн гарч чиглэлд хяналт шалгалтыг 18 удаа машинтайгаар гарч ажилаж байна.</p>	<p>100</p>

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ

Ажил, арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт	Хувь
3.1.Тариалангийн талбайн түүхийн дэвтэр хөтлөлтийг тогтмолжуулж, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах	Тариалангийн газар эзэмшигч 6 аж ахуйн нэгж, давуу эрхийн тариаланч 11 иргэнтэй байгуулсан гэрээнд тусган ажиллаж байна. Тариалангийн талбайн түүх хөтлөлтийн дэвтэр хэвлэгдэж гараагүй боловч технологийн карт мөрдүүлэн ажиллаж байна.улаан буудайн дээр гарал үүслийн бичиг дагалдах бичиг болгож ТЭДСанд урамшуулалын материал өгч байна.	70
3.2.Тариалангийн талбайг хянан баталгаанд бүрэн хамруулж “Хөрсний төлөв байдлын нэгдсэн сан”-тай болох	Сэлэнгэ аймгийн ГХБХБГазраас 2017 онд тариалангийн болон атаршсан газрын төлөв байдал чанарын хянан баталгааны ажлыг “ВЕКТОР МЭП” ХХК-аар хийлгэхээр гэрээ байгуулсан бөгөөд уг компанитай 2017 оны 06-р сарын 23,24 –ны өдрүүдэд хамтарч ажиллан нийт 253 тариалангийн талбайн хөрснөөс дээж авсан. Ингэснээр “Хөрсний төлөв байдлын сан”-д мэдээллийг байршуулах бүрэн боломжтой боллоо.	100
3.3. Ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээ, тэг элдэншүүлэг, хөрс хамгаалах технологийн сургалт, талбайн өдөрлөгийг Ерөө, Сайхан, Мандал суманд зохион байгуулах	Хөрсний үржил шимийг тогтвортой дээшлүүлэх арга ажиллагаанд Арвин бэлчир ХХК, Монгол сафори ХХК, Хурниад Хүдэр ХХК, Ургац Хүдэр ХХК нь сүрлэн хучилттай 0 элдэншүүлэлтэй уриншийг жил болгон хийж тариалалтын үед Холимог бордоо, Азотын бордоогоор бордон тариалж байна. Сумын тэргүүний тариаланчдыг шалгаруулах үзүүлэлтэнд “Хөрс хамгаалах, сэлгээний тарималыг олшруулах, тэг элдэншүүлгийг нэвтрүүлсэн байдал”-ыг тусган, мөрдөж Улсын аварга тариаланч хамт олноор Ургац Хүдэр ХХК нь шалгарлаа.	70
3.4. Тариалангийн хөрс хамгаалах дэвшилтэт арга ажиллагааг газар эзэмшигч, ашиглагчтай байгуулах гэрээнд тусгаж, гүйцэтгэлийг тооцох	Хөрсний үржил шимийг тогтвортой дээшлүүлэх арга ажиллагаанд Арвин бэлчир ХХК,Монгол сафори ХХК,Хурниад Хүдэр Ургац Хүдэр ХХК нь сүрлэн хучилттай 0 элдэншүүлэлтэй уриншийг жил болгон хийж тариалалтын үед Холимог бордоо,Азотын бордоогоор бордон тариалж байна. сумын тэргүүний тариаланчдыг шалгаруулах үзүүлэлтэнд “Хөрс хамгаалах, сэлгээний тарималыг олшруулах, тэг элдэншүүлгийг нэвтрүүлсэн байдал”-ыг тусган, мөрдөж Улсын аварга тариаланч хамт олноор Ургац Хүдэр ХХК нь шалгарлаа.	70
3.5. Услалтын системүүдийг албан ёсоор бүртгэлжүүлж, ашиглалтгүй талбайг хуулийн дагуу хурааж, дахин хуваарилах арга хэмжээг зохион байгуулах	Арвин бэлчир ХХК нь услалтын систем ашиглаж 80га-д усалгаатай тариалалт хийлээ. Хүдэр сум 2016 онд 2ААНэгж улсын аварга ХХК-наар шалгарч Ургацын баяраараа хамтран тэмдэглэсэн. Услалтын системийг Арвин бэлчир ХХК, Монгол сафори ХХК ашиглаж га-гаас авах ургацын хэмжээ энэ жил гантай жилийн хувьд 10цн буюу 160тн улаан буудай хураан авлаа..	70

<p>3.6. Мал сүрэгт хийгдэх үзлэг ангилалт болон үхэр, цөм сүргийн малыг ээмэгжүүлэх, бүртгэлжүүлж, санд оруулах ажлыг графикт хугацаанд нь хийж гүйцэтгэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах</p>	<p>Эрчимжсэн МАА-г хөгжүүлэх чиглэлээр махны чиглэлийн “Ангус”үлдэрийн 3 хээлтүүлэгчийг 3 малчинд гэрээний дагуу эзэмшүүлж цөм сүрэг бий болгох бодлого баримтлан ажиллаж байна. Өндөр шимт малын тоог нэмэгдүүлэх зорилгоор сумын нийт үхэр сүрэгт ашиг шим үзүүлэлтийн ангилалт хийхэд нийт үхэр сүргийн 80 хувь нь “Сэлэнгэ” үлдэр болон махны чиглэлийн “Лимузин” үлдэрийн эрлийз үхэрт ангилагдсан. Ангилалтын ажил хийж гүйцэтгэхэд Аймгийн ХХАА-н газраас 260,0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан.</p>	<p>70</p>
<p>3.7. Малын ашиг шимийн хяналтын хэмжилтийг сум, баг, хот айлын түвшинд нарийвчлан тогтоож, мэдээллийн санд төвлөрүүлэх</p>	<p>Хэрэгжээгүй</p>	<p>0</p>
